

2/2



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/592

Улаанбаатар хот


Боловсролын зээлийн сангийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оросын Холбооны Улсын Эрхүү хотын Хөдөө аж ахуйн их сургуулийн эдийн засгийн ангид элсэн орсон хөгжлийн бэрхшээлтэй оюутан Батбаатар овогтой Болорыг Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцуулсугай.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийг үндэслэн төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /М.Ариунжаргал/-д энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын бодлогын газар /Т.Амаржаргалан/-т тус тус даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА